

Тендерийн баримт бичигтэй танилцсан:

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ХУРАНДАА Д.ДАМДИНЦЭРЭН



**“ШАТАХУУН” НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН  
САНАЛЫН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ

Тендер шалгаруулалтын код

ШШГЕГ/20200522

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос түлш, шатахуун нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /ADOBE PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.

Тендер шалгаруулалтын нэр: **“Шатахуун” нийлүүлэх**

Тендерийн дугаар: **ШШГЕГ/2020**

Батлагдсан төсөвт өртөг: **49,017,800 төг**

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим тендер шалгаруулалтын журмаар авна.

Үнийн саналыг цахим тендерын журмаар **2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 10 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) –ээс авах ба тодруулга болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 2-р хороо, Бага тойруу 13/1, өөрийн байр, харилцах утас: 324643 99277092*

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

**7. Санал  
болгосон үнэ,  
түүнийг  
үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах  
эрх олгох  
тухай  
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу / 2018 он, 2019 он/ /Худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –ээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн мэдээллийн сан e-balance –аас шаардлагатай мэдээллийг давхар шалгана.</p> <p>Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.</p> <p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018 он, 2019 онуудад оролцож буй багцад хамаарах ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох, гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбар ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүх төрлийн шатахуун шингэрүүлсэн шатдаг хийг импортлох, бөөнөөр болон жижиглэнгээр худалдаалах тусгай зөвшөөрөлтэй байх</li> <li>- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>- Нийлүүлэх бараа нь чанар стандартын шаардлага хангасныг нотлох мэргэжлийн хяналтын байгууллагын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг, дүгнэлт</li> <li>- Барааны гарал үүслийн гэрчилгээ</li> <li>- Татварын цахим тодорхойлолт ирүүлэх</li> <li>- Тендерт шалгарсан байгууллага нь бараа нийлүүлэх явцад шатахууны октаныг 1-2 удаа тодорхойлуулахад татгалзах зүйлгүй зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх</li> </ul> <p>Тендерт оролцогч тендерийн материал Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, нээх хугацаа нь:</p> <p>Уг тендер нь “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-аар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь “Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>”- д нэвтрэн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Байгууллагын хаяг: <i>Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 2-р хороо, Бага тойруу 13/1, өөрийн байр, харилцах утас: 324643</i></p> <p>Огноо: <b>2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>

<b>ТӨӨЗ 3.1</b>	Баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 3 хоногоос багагүй байна.
<b>ТӨӨЗ 3.2</b>	Оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх бичиг баримт нь Монгол хэл дээр байна.
<b>ТӨӨЗ 3.3</b>	Оролцогч Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бараа нийлүүлэхтэй холбогдуулан үнийг бусад валютаар санал болгон ирүүлэхийг “зөвшөөрөхгүй.”
<b>ТӨӨЗ 3.4</b>	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “шаардлагагүй”

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Нийлүүлэгч нь хамгийн бага үнээр улирлын нөхцөлд тохирсон шатахууныг худалдан авагч талд жилийн туршид бэлэн бус хэлбэрээр /Шатахууны талон / олгох.
2. Нийлүүлэх авто шатахуун нь ОХУ-ын ГОСТ Р 51105-97 стандартын дагуу үйлдвэрлэгдсэн болон түүнтэй дүйцэхүйц чанар стандартыг хангасан байна. Өөр гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тохиолдолд тухайн барааг үйлдвэрлэсэн стандарт нь Монгол улсын MNS 216:2006, MNS 217:2006 стандартыг хангаж байгааг нотолсон бичиг заавал ирүүлнэ.
3. Нийлүүлэгдэх бараа “АИ-92” нь үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлнэ. Холбогдох стандартад нийцэж байгаа болон түүнээс илүүгээр хангаж байгааг харуулсан дагалдах бичгүүдийг заавал хавсаргана.
4. ШТС-ийн салбарууд нь хөдөө орон нутгийн 21 аймагт салбартай байх.

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
АИ-92 бензин	Автобензин	34000	литр	ШШГЕГ	Гэрээг байгуулснаас хойш хуанлийн 3 хоног	Гэрээний хугацаанд буюу 12 сард	

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг / утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших

1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт

2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх

3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх

4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа

5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[0]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах

6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр

7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь

8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах

9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

**10. Үүргээ  
биелүүлээгү  
й-гээс гэрээг  
цуцлах**

10.1 Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**11. Маргааныг  
шийдвэрлэх**

11.1 талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

### 1. Шалгах болон турших

(ГЕН – 1)

1.1. Шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулна.

### 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)

“Монгол улсын гаднаас санал болгосон бараа: Incoterms 2010 DDP” Шатахууныг жилийн туршид тасралтгүй хангах бөгөөд зах зээл дээр шатахууны хомсдол гарсан нөхцөлд гэрээт байгууллагын үйл ажиллагааг зохих түвшинд хангах шатахууны нөөцтэй байх.

421 дүгээр нээлттэй хорих ангийн ажил, үйлчилгээ эрхэлж буй машин техникт “24” цагийн турш очер дараалалгүй үйлчлэх. байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ; Барааны гарал үүслийн гэрчилгээ.

### 3. Баталгаат засвар

(ГЕН-5)

5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө.

5.2 Үйлчилгээний явцад шатахууны төрлийг андуурч олгосноос үүдэлтэй техникт гарсан эвдрэлийг нийлүүлэгч тал хариуцна гэсэн мэдэгдэл ирүүлэх

### 4. Төлбөр

(ГЕН – 7)

7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуухийнэ.

1. **Урьдчилгаа төлбөр:** Байхгүй

2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** Байхгүй.

3. **Барааг хүлээн авахад төлөх төлбөр:** 100 хувь

Барааны төлбөрийг гүйцэтгэлээр нь буюу бараа хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.

### 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>

9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5%

Алдангийн нийт дүн: 10% иас хэтрэхгүй байна.

1 Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ4

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Бусад шаардлагатай баримт бичиг5;
- Үнийн санал;
- Гэрээний тусгай нөхцөл;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- Санхүүжилтийн хуваарь.

4 Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5 Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын*  
*үсэг]* \_\_\_\_\_  
ТАМГА  
*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын*  
*үсэг]* \_\_\_\_\_  
ТАМГА  
*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*